



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 223

Улаанбаатар хот

┌ Үндсэн хөрөнгө балансаас балансад ┐  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Засгийн газрын автобааз” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 248,600,000.00 (хоёр зуун дөчин найман сая зургаан зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 209,620,067.84 (хоёр зуун есөн сая зургаан зуун хорин мянга жаран долоон төгрөг наян дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу төрийн өмчит байгууллагуудад балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Засгийн газрын автобааз” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Г.Чинзориг, “И Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Б.Мягмарнаран, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга Х.Энхбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005556

17-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 06 дугаар сарын 2-ны өдрийн  
2.23 дугаар тогтоолын хавсралт

"ЗАСГИЙН ГАЗРЫН АВТОБААЗ" ТӨААТҮГ-ЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
ТӨРИЙН ӨМЧИТ БАЙГУУЛЛАГУУДАД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/а шиглалтад орсон огноо	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шилжүүлэн авах байгууллага
1	Ренаулт Логан, 03-51 УБО, Х7L4SRLTB61896742	2018/2019	33,600,000.00	12,880,000.00	20,720,000.00	И Монгол академи улсын төсөвт үйлдвэрийн газар
2	Лексус-570, 07-08 УНБ, JTJHY7AX1B4075637	2015/2015	215,000,000.00	196,740,067.84	18,259,932.16	Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо
	<b>НИЙТ ДҮН</b>		<b>248,600,000.00</b> (хоёр зуун дөчин найман сая зургаан зуун мянган)	<b>209,620,067.84</b> (хоёр зуун есөн сая зургаан зуун хорин мянга жаран долоон төгрөг наян дөрвөн мөнгө)	<b>38,979,932.16</b> (гучин найман сая есөн зуун далан есөн мянга есөн зуун гучин хоёр төгрөг арван зургаан мөнгө)	